МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
14251 Улаанбаатар хот.
Сүхбаатар дүүрэг. Чингисийн өргөн чөлөө 11.
Утас: (976) 51-267168. Факс: (976) 11-312315.
E-mail: info@mrtd.gov.mn. http://www.mrtd.gov.mn

2023.01.10 № 03/91
танай ____________ -ны № ____________ -т

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Т.ЭНХБАЯР
ТАНАА

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8-д "төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сум, дүүргийн Засаг дарга дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор Жендэрийн үндэсний хороонд тус тус хүргүүлэх" гэж заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны хүйсийн тэнцвэрт байдлын болон Зам, тээврийн хөгжлийн яамны жендэрийн салбар зөвлөлийн 2022 оны тайланг хүргүүлж байна.

Хавсралт 15 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД

9020000420 5919437 СБА7589

080000215

Боловсруулсан:
Хянас:
Хувь: 2
Огноо: 2013.01.29

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн өдрийн 03/91 тоот албан бичгийн хавсралт

**Жендэрийн салбар зөвлөлийн гишүүдийн товч мэдээлэл**

| № | Салбар зөвлөлийн гишүүний нэр | Хүйс | Байгууллага, албан тушаал мэргэжил | Улсад ажилласан жил | Жендэр ба бодлого төлөвлөлт" анхан шатны сургагч багшийн гэрчилгээ авсан эсэх | Жендэрийн цахим сургалтад хамрагдсан эсэх | Утасны дугаар | Цахим хаяг | Жендэрийн салбар зөвлөлийн чиг үүргийн хүрээнд хариуцаж буй үйл ажиллагааны чиглэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | С.Батболд | эр | Төрийн нарийн бичгийн дарга | 27 жил | тийм | тийм | 99109945 | batbolds@mrtd.gov.mn | Салбар зөвлөлийн дарга |
| 2. | Б.Болор-Эрдэнэ | эр | Бодлого төлөвлөлтийн газрын дарга | 18 жил | тийм | тийм | 91114576 | bolorerdene@mrtd.gov.mn | Салбарын бодлого |
| 3. | А.Мөнхбат | эр | ХШҮДАГ-ын дарга | 18 жил | үгүй | үгүй | 99882585 | munkhbat@mrtd.gov.mn | Хяналт шинжилгээ үнэлгээ |
| 4. | Б.Нямдаваа | эр | Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга | 21 жил | Үгүй | үгүй | 93096035 | nyamdavaa@mrtd.gov.mn | Гадаад хамтын ажиллагаа |
| 5. | Э.Бадамсүрэн | эр | ТЗУГ-ын хүний нөөцийн ахлах шинжээч | 9 жил | үгүй | үгүй | 99131955 | badamsuren@mrtd.gov.mn | Хүний нөөц |
| 6. | Я.Ганцэцэг | эм | Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн | 19 жил | үгүй | үгүй | 99884177 | gantsetseg@mrtd.gov.mn | Хөдөлмөрийн аюулгүй байдал |
| 8. | Ч.Мөнхтуяа | эм | ИНЕГ-ын дарга | 30 жил | Тийм | Тийм | 99113244 | munkhtuya@mrtd.gov.mn | Агентлагийн төлөөлөл |
| 9. | Х.Энэрэлсайхан | эм | Монголын авто замчин эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн | 10 жил | Үгүй | - | 88085889 | - | ТББ-ын төлөөлөл |
| 10 | С.Мяндасмаа | Эм | ХХ-ийн ахлах шинжээч | 20 жил | Тийм | Тийм | 88091048 | myandasmaa@mrtd.gov.mn | Жендэрийн мэргэжилтэн |

БАТЛАВ.
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ЖЕНДЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА С.БАТБОЛД

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ**

**ЖЕНДЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ | Төсөв | Санхүүжилтийн эх үүсвэр | ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | СУУРЬ ТҮВШИН | Зорилтот түвшин | ХАРИУЦАХ АЛБАН ТУШААЛТАН |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Зорилт 1.**Зам, тээврийн салбарын хэмжээнд жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, ойлголтыг бүх түвшинд нэмэгдүүлж,Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх<br>**Үр дүн:**Зам, тээврийн салбартбодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээг жендэрийн мэдрэмжтэй хийх чадавхи болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. | | | | | | |
| 1. | Жендэрийн салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулж, холбогдох асуудлыг тухай бүр хэлэлцэж дүгнэлт, шийдвэр гаргах | - | | Хурлын тоо | Хурлын төлөвлөгөө, хэлэлцэх асуудлын дараалал батлагдсан. | Жилийн турш | Жендэрийн салбар зөвлөлийн нарийн бичиг |
| 2. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөгөө, хөтөлбөрийн үндсэн дээр хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар ажилтнуудад мэдээлж ажиллах | - | | Тайлангийн тоо | Төлөвлөгөө батлагдсан. | Жилийн турш | Жендэрийн мэргэжилтэн |
| 3 | Албан хаагчдаас “Ажлын байрны дарамт”-ын талаар судалгаа авах ажлыг зохион байгуулах | - | | Судалгаанд оролцогчдын тоо | Судалгааны асуулга боловсруулсан. | 1 дүгээр улирал | Жендэрийн мэргэжилтэн |
| 4 | Шинээр ажилд орсон албан хаагчдад зориулсан жендэр, байгууллагын соёл, хүний эрхийн асуудлыг тусгасан сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулах | 3,000.000 | Улсын төсөв | Сургалтанд оролцогсдын тоо | Сургалтын хөтөлбөр боловсруулсан. | 1 дүгээр улирал | Жендэрийн мэргэжилтэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Харьяа байгууллагуудын ажлын байр хуульд заасан нөхцөл, шаардлага хангаж буй эсэхийг судлах | - | | Судалгаанд оролцогсдын тоо | Асуулга боловсруулсан. | 2 дугаар улирал | Жендэрийн мэргэжилтэн, ХАБЭА-н нарийн бичгийн дарга |
| 6 | Жендэрийн хэвшмэл ойлголт, тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр боловсруулах | 1.000.000 | Улсын төсөв | Сургалтын хөтөлбөр боловсруулсан байх | Сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон. | 3 дугаар улирал | |
| 7 | Салбарын хэмжээнд болон байгууллагын түвшинд жендэрийн хэвшмэл ойлголт, тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах | 1.500.000 | Улсын төсөв | Сургалтын тоо | Сургалтын хэрэгцээг тодорхойлсон. | 3 дугаар улирал | Жендэрийн мэргэжилтэн |
| 8 | Харьяа байгууллага бүрт жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, тайлагнах удирдамж боловсруулан хүргүүлэх | - | | Хамрагдах байгууллагын тоо | Төлөвлөгөө батлагдсан. | 3 дугаар улирал | Жендэрийн мэргэжилтэн |
| 9 | Салбарын хэмжээнд Ёс зүйн болон сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдын жендэрийн байдалд дүн шинжилгээ хийж тайлагнах | - | | Сахилгын шийтгэлтэй албан хаагчдын тоо | Сахилгын шийтгэл ногдуулсан тушаал гарсан | 2 дугаар улирал | Жендэрийн мэргэжилтэн |
| 10 | Салбарын хэмжээнд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлагыг өөрчлөх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах | - | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Төлөвлөгөө гарсан | Жилийн турш | Жендэрийн салбар зөвлөлийн нарийн бичиг, гишүүд |
| 11 | Эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах замаар эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулах талаар байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д тусгах | - | | Дотоод журамд заалт оруулсан байгууллагын тоо | Дотоод журамтай батлагдсан. | Жилийн турш | Жендэрийн салбар зөвлөлийн нарийн бичиг, гишүүд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Зорилт 2.Салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлэх, ашиглах чадавхыг дээшлүүлэх, жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс ангид ажлын орчин бий болгох**<br>**Үр дүн:**Хүйсээр ангилсан мэдээллийн нэгдсэн санг хүний нөөцийн бодлого төлөвлөлтөнд ашиглаж, эрэгтэй, эмэгтэй албан хаагчдад тэгш болох бүрдүүлэхүйц байгууллагын соёл, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх механизм ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрт байдлыг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй ажлын орчин бэрдэнэ. | | | | | | |
| 12. | Төрийн захиргааны төв байгууллагаас хүйсээр ангилсан мэдээллийн сан бүрдүүлэх | - | | Мэдээллийн сан ашиглах нөхцөл бүрдсэн байх | Зам, тээврийн салбарын мэдээллийн санг ашиглаж эхэлсэн. | 4 дүгээр улирал | Жендэрийн салбар зөвлөлийн нарийн бичиг, гишүүд |
| 13. | Хүйсээр ангилсан мэдээллийг бүрдүүлэх, нэгтгэх, тайлагнах тогтолцоог салбарын хэмжээнд бий болгох | -- | | Мэдээллийн сангийн асуулга бүрдсэн байх | Мэдээллийн сан бүрдсэн | 4 дүгээр улирал | Жендэрийн салбар зөвлөлийн нарийн бичиг, гишүүд |
| 14. | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд "Хүйсээр ялгаварлан гадуурхах, ажлын байрны бэлгийн дарамтын талаарх гомдол хүлээн авах, шийдвэрлэх" талаар тусгах | - | | Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байгууллагын тоо | Дотоод журам батлагдсан. | 2 дугаар улирал | Жендэрийн мэргэжилтэн |
| 15. | Ажлын байран дахь нас, хүйсийн ялгаварлан гадуурхалт болон ажлын байрны бэлгийн дарамтын талаарх мэдлэг олгох сургалтыг салбарын хэмжээнд зохион байгуулах | 2.000.000 | Улсын төсөв | Сургалтын тоо | Хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон. | Жилийн турш | Жендэрийн мэргэжилтэн |
| 16. | Албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж байгаа сайн туршлага, үйл ажиллагааг сурталчлах | 1.500.000 | Улсын төсөв | Сайн туршлага судалсан тоо | Судалгаа гаргасан. | Жилийн турш | Жендэрийн мэргэжилтэн |
| 15. | Жендэрийн асуудлаар төр-иргэний нийгэм-хувийн хэвшил-олон улсын түншлэгчдийн олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх | 1.000.000 | Улсын төсөв | Хамтран ажилласан байгууллагын тоо | Хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлсон. | Жилийн турш | Жендэрийн салбар зөвлөлийн нарийн бичиг, гишүүд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16. | Ажилд авах, ажлаас халахад нас, хүйсээр ялгаварлан гадуурхах байдлыг бууруулах | - | | Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан тоо | Ялгаварлан гадуурхалтыг бууруулах талаар судалгаа авсан. | Жилийн турш | Жендэрийн салбар зөвлөлийн нарийн бичиг, гишүүд |
| 17. | Салбарын хэмжээнд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийж, зөвлөмж гарган хэрэгжилтийг хангах | 1.500.000 | Улсын төсөв | Үнэлгээ хийгдэж зөвлөмж хүргүүлсэн байх | Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний асуулга гарсан. | 4 дүгээр улиралд | Жендэрийн салбар зөвлөлийн нарийн бичиг, гишүүд |
| 18. | Ажлын байрны аливаа дарамт, нас, хүйсээр ялгаварлан гадуурхалт байгаа эсэхийг асуулгын аргаар судалгаа хийх | - | | Судалгааны оролцогчдын тоо | Судалгаанд оролцох байгууллагыг түүврийн аргаар сонгосон. | 1 дүгээр улиралд | Жендэрийн мэргэжилтэн |
| | **Зорилт 3.Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх**<br>**Үр дүн:** Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ жендэрийн мэдрэмжтэй болж, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгмийн оролцоог тэгш хангах орчин бүрдэнэ. | | | | | | |
| 19. | ЗТХЯ-ны харьяа байгууллагуудад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11.1, 11.2, 11.3.9-р зүйлүүдийн хэрэгжилтийн талаарх үнэлгээ, судалгааг хийх | - | | Судалгаанд хамрагдсан байгууллагын тоо | Судалгааны асуулга боловсруулсан. | 3 дугаар улиралд | Жендэрийн мэргэжилтэн |
| 20. | Харьяа байгууллагад ашиглахад зориулсан ажлын орчин нөхцөлийн жендэрийн мэдрэмжийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох | - | | Шалгуур үзүүлэлтийн тоо | Ажлын байрны нөхцөлийн судалгаа хийсэн. | 4 дүгээр улиралд | Жендэрийн салбар зөвлөлийн нарийн бичиг, гишүүд |
| 21. | Салбарын байгууллагуудаас хийж буй судалгаа, үнэлгээ, хэрэглэгчээс авах судалгаанд нас, хүйсийн үзүүлэлтийг оруулах, үр дүнг тайлагнахдаа хүйсээр ангилж дүн шинжилгээ хийх удирдамж гаргах | - | | Хүйсээр ангилсан мэдээлэл ашигласан тоо | Судалгаанд ашиглах нөхцөл бүрдсэн. | 3 дугаар улиралд | Жендэрийн салбар зөвлөлийн нарийн бичиг, гишүүд |
| 22. | Зам, тээврийн салбарын хэрэглэгчийн судалгааг жендэрийн мэдрэмжтэй болгох | 3.000.000 | Улсын төсөв | Хэрэглэгчийн судалгааны асуулгын агуулгыг | Хэрэглэгчийн судалгааны асуулга гарсан. | 4 дүгээр улиралд | Жендэрийн салбар зөвлөлийн нарийн бичиг, гишүүд |

--ooOoo--

**МОНГОЛ УЛСЫН**
**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН**
**САЙДЫН ТУШААЛ**

2022 оны 12 сарын 30 өдөр | Дугаар А/341 | Улаанбаатар хот

Жендэрийн салбар зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолоор баталсан Жендэрийн үндэсний хорооны дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий "Жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг нэгдүгээр, "Жендэрийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус батласугай.

2.Жендэрийн асуудал хариуцсан орон тооны бус мэргэжилтнээр Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн ахлах шинжээч С.Мяндасмааг томилсугай.

3.Жендэрийн орон тооны бус мэргэжилтэн С.Мяндасмаад албан тушаалын цалингийн 30 хувийн нэмэгдэл олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст зөвшөөрсүгэй.

4.Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Салбар зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

5.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 201 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД С.БЯМБАЦОГТ

9020050420 5919487 CБА7589

080000005

Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2022 оны 12 дугаар сарын 30 ны өдрийн [illegible] дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

9020050420 5919487 CEA7529

ЖЕНДЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү журмын зорилго нь Жендэрийн салбар зөвлөлийн зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаа болон түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2.Салбар зөвлөл нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Жендэрийн үндэсний хорооны дүрэмд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий яамны хэмжээнд ажиллах Жендэрийн үндэсний хорооны зохион байгуулалтын бүтцийн нэгж юм.

## ХОЁР. САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1.Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Зам, тээврийн хөгжлийн Сайдын тушаалаар батлуулж мөрдөнө.

2.2.Салбар зөвлөл нь ажлаа Сайдын өмнө хариуцан тайлагнана.

2.3.Салбар зөвлөл нь харьяа байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангасан байх ба аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас багагүй байна.

2.4.Салбар зөвлөл нь салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.5.Салбар зөвлөл нь харьяа агентлаг, байгууллагад дэд зөвлөлтэй байна.Дэд зөвлөл нь бүрэлдэхүүн, үйл ажиллагааны дүрмийг энэхүү журамд нийцүүлэн боловсруулж, байгууллагын удирдлагын шийдвэрээр баталж мөрдөнө. Дэд салбар зөвлөл нь салбар зөвлөлийн өмнө ажлаа хариуцан тайлагнана.

2.6.Салбар зөвлөл нь дэд салбар зөвлөлийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.

2.7.Яамны жендэрийн салбар зөвлөл нь 11-15 хүртэл, дэд зөвлөл нь 5-9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.8.Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Салбар зөвлөлийн хуралдааныг жилд 4-өөс доошгүй удаа /улирал тутам/ зохион байгуулна. Хуралдааныг салбар зөвлөлийн дарга удирдан явуулна.

2.9.Шаардлагатай тохиолдолд салбар зөвлөлийн ээлжит бус хурлыг салбар зөвлөлийн даргын санаачилгаар, зарлан хуралдуулж болно. Гишүүдийн 50- аас доошгүй хувь ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.

**3.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хүрээнд:**

3.2.1.Салбар зөвлөлийн гишүүдийн жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, холбогдох бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар тусгах, хэрэгжилтийг үнэлэх хүрээнд жендэрийн мэдрэмжтэй шалгуур, үзүүлэлтийг боловсруулж, хяналт үнэлгээний тогтолцоонд нэвтрүүлэх;

3.2.2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтэд оролцоонд суурилсан хяналт шинжилгээг жил бүр үнэлгээг хууль, бодлогод заасан хугацаанд тус тус хийж гүйцэтгэх, дүнг Жендэрийн үндэсний хороонд тайлагнах;

3.2.3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтэд оролцоонд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээний байгууллагыг татан оролцуулах.

**3.3.Жендэр статистик мэдээллийг бүрдүүлэх, ашиглах, олон нийтэд хүргэх хүрээнд:**

3.3.1.Салбарын хэмжээнд эрхэлж буй асуудлын хүрээнд хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг бүрдүүлэх;

3.3.2.Салбарын хүйсээр ангилсан статистикийн мэдээлэлд үндэслэн жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх, үнэлгээнд үндэслэн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авах;

3.3.3.Салбарын хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг эмхтгэн, хэрэглэгчдэд хүргэх ажлыг зохион байгуулах;

3.3.4.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8, 19.1.9-д заасан тайланг бэлтгэх ажлыг хариуцан зохион байгуулах;

**3.4.Жендэрийн сургалт, судалгаа, гэгээрлийн ажлын хүрээнд:**

3.4.1.Салбарын ажилтан, албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг таниулан сурталчлах;

3.4.2.Жендэрийн үндэсний хорооны цахим хуудаст байрших "Удирдах албан тушаалтнуудад зориулсан жендэрийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх цахим сургалт"-д хамрагдаж, гэрчилгээ авах;

3.4.3.Салбарын мэдээлэл, гэгээрэл, сурталчилгааны ажлыг эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх, хүнийг ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах зорилгод нийцүүлэн зохион байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

3.4.4.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомж, төрийн бодлого, тэдгээрийг хэрэгжүүлж буй сайн туршлагыг иргэд,аж ахуйн нэгж байгууллагуудад таниулан сурталчлах ажлыг хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

3.4.5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэний үйл ажиллагааг дэмжиж, тэдгээртэй хамтран ажиллах;

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 4/31 дугаар тушаал

4.1.Салбар зөвлөлийн дарга нь Жендэрийн үндэсний хорооны гишүүн байх бөгөөд Сайдын өмнө ажлаа хариуцаж дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1.Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн зорилго, стратегийг тодорхойлох;

4.1.2.Салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэд зөвлөлийн үйл ажиллагаатай уялдуулан нийцүүлэх, нэгтгэн зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

4.1.3.Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоон хөтөлбөрийг баталж, хуралдааныг даргалан холбогдох асуудлыг хэлэлцүүлэх;

4.1.4.Салбар зөвлөлийн гишүүдийн хариуцах ажил үүргийг тухайн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлтийн хамт тусгуулж, биелэлтийг тооцох;

4.1.5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар сайдад тайлагнах, өгсөн чиглэл, үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангах;

4.1.6.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан холбогдох тайлан, мэдээллийн бодит байдалд хяналт тавих,

4.1.7.Салбар зөвлөлийг төлөөлөн бусад байгууллага, албан тушаалтантай харилцах;

4.1.8.Салбар зөвлөлийн гишүүний ажил үүргийн биелэлтийг дүгнэж, урамшуулах, шаардлага тавих, хариуцлага хүлээлгэх;

4.1.9.Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын ачаалал, үр дүн, ур чадвартай нь уялдуулан холбогдох хууль, журамд нийцүүлэн дэмжих, урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах;

4.1.10.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр зарцуулж буй төсвийн зарцуулалтад хяналт тавих.

**4.2.Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:**

4.2.1.Салбар зөвлөлийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л асуудлаар Салбар зөвлөлийн даргад дэмжлэг үзүүлж ажиллах.

4.2.2.Салбар зөвлөлийн дарга, гишүүдийг жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх холбогдох мэдээ мэдээллээр хангах;

4.2.3.Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж, гишүүдэд урьдчилан танилцуулж, санал авах, нэгтгэн боловсруулах;

4.2.4.Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг салбар зөвлөлийн даргаар батлуулах;

4.2.5.Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам тооцож, салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулан хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;

4.2.6.Салбар зөвлөлийн хуралдааны биелэлтийг хангах, хуралдааны шийдвэр, тэмдэглэлийг зохих журмын дагуу албажуулах, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

МОНГОЛ УЛСЫН ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Тэргүүн нарийн бичгийн дарга 2022 оны 11/34 тушаал

Хавсралт 2

# ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГИЙН ТАЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙГДСЭН ТАЙЛАН

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/236 тоот тушаалаар баталсан "Зам, тээврийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг 2022 онд хэрэгжүүлэв.

| Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол шалтгаан, нөхцөл байдал/ | Салбар зөвлөлийн өөрийн үнэлгээ | ХҮШДАГ-ын үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго:Зам, тээврийн салбарын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендэрийн агуулгыг тусгах, жендэрийн талаарх мэдлэг ойлголт, хандлагыг өөрчлөх, салбарын үр шимийг эрэгтэй эмэгтэй хүмүүст тэгш хүртээх, гэр бүлд ээлтэй хөдөлмөрийн харилцааны орчин нөхцөлийг бүрдүүлэх, бүх хүрээнд хамтын ажиллагаа түншлэлийг хөгжүүлэх замаар жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд энэхүү бодлогын зорилго оршино.** <br><br> **Зорилт.1.**Зам, тээврийн салбарын хэмжээнд жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, ойлголтыг бүх түвшинд нэмэгдүүлж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх | | | | | | | |
| Ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар гарын авлага боловсруулах | | Гарын авлагын тоо | Гарын авлагын агуулгыг бэлдсэн | Гарын авлагыг боловсруулсан ашигласан байх | Хөмнэлтийн тухай хууль 2022 оны 5 дугаар сард хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан гарын авлага хэвлүүлэх шаардлагагүй гэж үзсэн. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх гарын авлага, материал хангалттай байв. | - | - |
| Зам, тээврийн салбарын хэмжээнд жендэрийн бодлогыг сурталчлах сургалт зохион байгуулах | | Зохион байгуулсан сургалтын тоо-1 | Сургалтын төлөвлөгөө батлуулсан | Харьяа байгууллага бүрд танилцуулах арга хэмжээ зохион байгуулах | Зам, тээврийн салбарын хэмжээнд жендэрийн бодлогыг сурталчлах сургалтыг ЗТХЯ, харьяа байгууллагын албан хаагчдыг хамруулан 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр цахимаар зохион байгуулав.<br>ЖҮХ-той хамтран 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/" баримт | 100% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бичгийн талаар Зам ,тээврийн хөгжлийн яамны албан хаагчдад мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулав. | | |
| Удирдах ажилтнуудад зориулсан жендэрийн сургалтын цахим хөтөлбөрийг салбарын үйл ажиллагаанд нийцүүлэн нэвтрүүлэх | | Үйл ажиллагааны тоо-1 | Сургалтын хөтөлбөр боловсруулсан. | Сургалтад ашиглах | Жендэрийн үндэсний хорооны ажлын албаны цахим хуудсан дахь "Төрийн албаны удирдах ажилтанд зориулсан" цахим сургалтыг Зам, тээврийн салбарын удирдах ажилтны 2022 оны 10 дугаар сарын 01-02-ны өдрийн сургалтад ашигласан. | 100% | 100% |
| Шинээр ажилд орсон ажилтанд зориулсан сургалтад жендэр, байгууллагын соёл, хүний эрхийн асуудлын талаар сургалт зохион байгуулах | 1,000,000 | Зохион байгуулсан сургалтын тоо | Сургалтыг төлөвлөсөн | Сургалтын агуулгыг сайжруулах | Төрийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлж буй "Төрийн албан хаагчийн шударга зарчимч байдлыг нэмэгдүүлэх нь" төсөлтэй хамтран "Байгууллагын соёл, ажлын байрны дарамт" сэдэвт сургалтыг шинээр ажилд орсон 11 албан хаагчийг хамруулан 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. | 100% | 100% |
| Зам, тээврийн салбарын байгууллагын цахим хуудсанд жендэрийн эрх тэгш байдлыг хангаж буй талаарх мэдээллийг байршуулах | | Байршуулсан мэдээллийн тоо-4 | Зохион байгуулах арга хэмжээг төлөвлөсөн. | Арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. | Яамны сайтад Жендэрийн эрх тэгш байдлыг хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар 4 удаа мэдээлэл оруулсан | 100% | 100% |
| Харьяа байгууллагуудын ажлын байр хуульд заасан нөхцөл, шаардлага хангаж буй эсэхийг судлах | 1.500.000 | Байгууллагын тоо-1 | | Төлөвлөгөө батлуулсан. | Ажлын байрны нөхцөл шаардлагад үнэлгээ хийж, хуулийн шаардлага хамгийн сайн хангасан "УБТЗ" ХНН-ийн Улаанбаатар татах хэсгийн ажлын байртай танилцах үйл ажиллагааг ХНХЯ-ны удирдлагууд болон эрчим хүч, барилга, уул уурхай, боловсрол зэрэг салбарын төлөөлөл танилцуулах ажлыг 2022 оны 04 дүгээр сард зохион байгуулсан. | 100% | 100% |
| Салбарын хэмжээнд | | Танилцуулсан | Салбарт | Удирдах | Удирдах ажилтны зөвлөгөөн 2022 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| баримтлах жендэрийн бодлого, түүний хэрэгжилтийг хангах асуудлыг салбарын бүх түвшиний шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдад танилцуулах | | арга хэмжээний тоо | жендэрийн талаар баримтлах бодлого батлуулсан. | ажилтны зөвлөгөөн зохион байгуулах | оны 5 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Хэмнэлтийн тухай хуультай холбогдуулан хойшлуулж "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ийг 2023 оны 1 дүгээр улиралд зохион байгуулахаар Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж баталгаажуулсан. | 0 | 0 |
| Салбарын хэмжээнд баримтлах жендэрийн бодлогыг сурталчлах гарын авлага боловсруулах | | Гарын авлага хүргүүлсэн байгууллагын тоо | Салбарт жендэрийн талаар баримтлах бодлого батлуулсан. | Харьяа байгууллагад сурталчилсан байх | Хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн салбарын хэмжээнд баримтлах жендэрийн бодлогыг сурталчлах ажлыг цахимаар 2022 оны 05 дугаар сард харьяа 3 байгууллагыг хамруулан зохин байгуулсан. | 100% | 100% |
| Салбарын хэмжээнд болон байгууллагын түвшинд жендэрийн хэвшмэл ойлголт, тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах | 2.500.000 | Зохион байгуулсан сургалтын тоо | Сургалтын төлөвлөгөө батлуулсан. | Харьяа байгууллагын хамруулан зохион байгуулах | Жендэрийн хэвшмэл ойлголт, тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх сургалтыг 2022 оны 8,9,10 дугаар сард Төрийн албаны зөвлөлтэй хамтран 3 түвшинд зохион байгуулсан.<br>а.Шинэ орсон албан хаагчдад<br>б.Гүйцэтгэх түвшний албан хаагчдад<br>в.Удирдах ажилтанд | 100% | 100% |

Тайлбар: Бодлогын Зорилт1-ийн хүрээнд 9 арга хэмжээнд 5.000.000 төгрөг зарцуулж, төсвийн зарцуулалт 100 хувь, үйл ажиллагааны хэрэгжилт 89% -тай байна.

Хавсралт 3.

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ, ХАРЬЯА АГЕНТЛАГТ АЖИЛЛАЖ БУЙ АЛБАН ХААГЧДЫН

## 2022 ОНЫ ХҮЙСИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫН ЖИЛИЙН МЭДЭЭ

**Маягт-1а**

| № | Төрийн захиргааны төв болон харьяа бусад байгууллагын нэр | Нийт албан хаагчид | |
|---|---|---|---|
| | | Эрэгтэй | Эмэгтэй |
| | Зам, тээврийн хөгжлийн яам | 71 | 63 |
| | Иргэний нисэхийн ерөнхий газар | 43 | 44 |
| | **Нийт** | **114** | **107** |

**Маягт-1б**

| № | Төрийн захиргааны төв байгууллагын нэр | Нийт улс төрийн албан хаагчид | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Эрэгтэй | Эмэгтэй | Сайд | | Дэд сайд | Бусад |
| | Зам, тээврийн хөгжлийн яам | 4 | | эр | | эр | эр |
| | | | | | | | |
| | **Нийт** | **4** | | **1** | | **1** | **2** |

**Маягт-1в**

| № | Төрийн захиргааны төв байгууллагын нэр | Нийт төрийн захиргааны албан хаагч | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төрийн нарийн бичгийн дарга | | Газар, хэлтсийн дарга | | Бусад гүйцэтгэх, туслах | |
| | | Эрэгтэй | Эмэгтэй | эр | эм | эр | эм | эр | эм |
| | Зам, тээврийн хөгжлийн яам | 68 | 57 | 1 | | 11 | 4 | 56 | 53 |
| | Иргэний нисэхийн ерөнхий газар | 2 | - | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийт | 70 | 57 | | | | | | |

**Маягт-1г**

| № | Төрийн захиргааны төв байгууллагын нэр | Нийт төрийн тусгай албан хаагч | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Эрэгтэй | Эмэгтэй | Төрийн нарийн бичгийн дарга | | Газар, хэлтсийн дарга | | Бусад гүйцэтгэх, туслах | |
| | Зам, тээврийн хөгжлийн яам | - | - | - | - | - | - | - | - |
| | Иргэний нисэхийн ерөнхий газар | | - | - | - | - | - | - | - |
| | Нийт | | | | | | | | |

**Маягт-1д**

| № | Төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын нэр | Нийт төрийн үйлчилгээний албан хаагч | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Эрэгтэй | Эмэгтэй | Газар, хэлтсийн дарга | | Бусад гүйцэтгэх, туслах | |
| | | | | эр | эм | эр | эм |
| 1 | Зам, тээврийн хөгжлийн яам | 3 | 6 | - | - | 3 | 6 |
| 2 | Иргэний нисэхийн ерөнхий газар | 43 | 44 | 11 | 1 | 32 | 43 |
| | **Нийт** | **46** | **50** | **11** | **1** | **35** | **49** |

Маягт 1е

| № | Хороо, зөвлөл, комиссын нэр | Байгуулсан шийдвэрийн нэр, дугаар огноо | Нийт дарга, гишүүдийн тоо | Дарга | | Гишүүд | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эр | эм | эр | эм |
| Салбарын сайдын ахалсан үндэсний болон салбарын хэмжээний | | | | | | | |
| 1 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөвлөл | | 4 | 1 | | 2 | 1 |
| | | | | | | | |
| Төрийн нарийн бичгийн даргын ахалсан хороо, зөвлөл, комисс | | | | | | | |
| 1 | Жендэрийн салбар зөвлөл | ЗТХ-ийн сайдын 2019.06.18 201 дугаар тушаал | 10 | 1 | | 5 | 4 |
| 2. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл | ЗТХ-ийн сайдын 2018.01.19. 15 | 26 | 1 | | 17 | 8 |
| 3. | НҮБ-ын Хүний эрхийн зөвлөмжийг хэрэгжүүлэх зөвлөл | ЗТХ-ийн сайдын 2017.06.15.217 дугаар тушаал | 17 | 1 | | 11 | 5 |
| 4. | Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах салбар зөвлөл | ЗТХ-ийн сайдын 2017.05.20. 43 дугаар тушаал | 35 | 1 | | 24 | 10 |
| 5. | Хүүхэд хөгжил хамгаалал үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг | ЗТХ-ийн сайдын 2017.03.16. 30 дугаар тушаал | 14 | 1 | | 8 | 5 |
| Харъяа агентлаг 1-ийн дэргэдэх хороо зөвлөл комисс | | | | | | | |
| 1. | Жендэрийн дэд зөвлөл | Газрын даргын 2018.03.15 25 дугаар тушаал | 19 | 1 | | 11 | 7 |
| 2. | Үйлдвэрчний эвлэл | | 50 | | 1 | 31 | 18 |
| 3. | Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн салбар зөвлөл | | 44 | | 1 | 25 | 18 |
| | **Нийт** | | **219** | **7** | **2** | **134** | **76** |